210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,605,900.00	5,605,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>65,047,400.00</b>	<b>65,018,172.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>65,047,400.00</b>	<b>65,018,172.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,123,000.00	6,122,672.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39,153,200.00	39,153,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,912,300.00	16,912,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,858,900.00	2,830,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>599,991,100.00</b>	<b>455,605,749.00</b>
220001	Барилга байгууламж	45,000,000.00	33,226,987.00
222001	Тоног төхөөрөмж	31,000,000.00	31,000,000.00
223001	Бусад хөрөнгө	523,991,100.00	391,378,762.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>100,000,000.00</b>	<b>0</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	100,000,000.00	0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,750,939,900.00</b>	<b>1,493,513,004.69</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>393,540,600.00</b>	<b>341,460,900.00</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	393,540,600.00	341,460,900.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,203,098,700.00</b>	<b>1,100,035,672.69</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,203,098,700.00	1,100,035,672.69
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>154,300,600.00</b>	<b>52,016,432.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,900,700.00	41,203,432.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,128,000.00	10,813,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	82,271,900.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	82,569,414.01
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	167,190,275.80
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>133</b>	<b>133</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>5</b>	<b>5</b>
610001	Төсвийн байгууллага	5	5
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>64</b>	<b>64</b>
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16
620003	Үйлчлэх ажилтан	37	37
620004	Гэрээт ажилтан	3	3
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>64</b>	<b>64</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	44	44
650010	Гэрээт ажилтан	3	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>118,883,861.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>118,883,861.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>115,685,940.00</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,684,760.00</b>
210303	Цэвэр, бохир ус	4,684,760.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,861,480.00</b>
210401	Бичиг хэрэг	245,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,556,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>610,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	610,000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>103,529,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,529,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,197,921.36</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,197,921.36</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	3,153,201.36
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	44,720.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>115,730,660.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>115,730,660.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,399,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,331,460.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-3,153,201.36</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,153,201.36

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум нь “Төрийн үйлчилгээг иргэдэд нээлттэй ил, тод, шуурхай байдлаар хүргэж, сумын нийгэм, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх замаар орон нутгийн хөгжлийн асуудлыг иргэд олон нийтийн оролцоонд тулгуурлан шийдвэрлэж хэрэгжүүлэхэд оршино” эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,827.4 сая төгрөгөөр буюу 29.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	/сая төгрөгөөр/ Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	264.4	247.6	-16.8
Авлага	281.6	202.2	-79.4
Бараа материал	232.6	72.1	-160.5
Үндсэн хөрөнгө	6,787.9	1,217.3	-5,570.6
Нийт хөрөнгө	7,566.7	1,739.3	-5,827.4
Өр төлбөр	10.8	0	10.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,555.9	1,739.3	-5,816.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,566.7	1,739.3	-5,827.4

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 16.8 сая төгрөгөөр буурсан нь ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил хийгдээгүй, хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт байна.
- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 79.4 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн бараа материал бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлсэн, мөн хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл 39.0 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагч нарт санхүүгийн тайланг нэгтгэж байгаа нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагч нарт санхүүгийн тайланг нэгтгэж байгаа нь нөлөөлсөн байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 247.6 сая төгрөг болж, өмнөх оноос 16.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)

Төрийн сангийн харилцах	242.9	246.8	3.9
Арилжааны банк дахь харилцах	18.3	0.78	-17.6
Нэмэлт санхүүжилтийн харилцах	3.1	0	-3.1
<b>Дүн</b>	<b>264.4</b>	<b>247.6</b>	<b>-16.8</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 247.6 сая төгрөгийн 246.6 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 0.8 сая төгрөг нь эргэлтийн эмийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийн 84.3 сая төгрөг буюу 34.0 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, 82.8 сая төгрөг буюу 33.4 хувийг ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт, 79.6 сая төгрөг буюу 32.1 хувь төрийн сангийн харилцахын оны эхний зарцуулагдаагүй үлдэгдэл тус тус эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт

- Байгууллага нь нийт 15 аж ахуйн нэгж байгууллага болон иргэдтэй холбоотой 21.5 сая төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна./ЗДТГ/

#### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 202.0 сая төгрөг болж, өмнөх оноос 79.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	1.1	0.00	-1.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	34.7	0.00	-34.7
Татаас, санхүүжилтийн авлага	13.1	12.7	-0.4
Дансны авлага /ТӨҮГ/	0.00	6.1	6.1
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.27	2.8	2.53
Байгууллагаас авах авлага	13.3	0.00	-13.3
Хувь хүмүүсээс авах авлага	218.9	180.4	-38.5
<b>Дүн</b>	<b>281.37</b>	<b>202.0</b>	<b>-79.4</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 193.1 сая, эмийн эргэлтийн сан 9.0 сая төгрөг байна.

#### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 72.2 сая төгрөг болж, өмнөх оноос 160.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	14	-	-14
Эм боох материал	24.2	26.2	2
Бичиг хэргийн материал	10.2	4.7	-5.5
Аж ахуйн материал	138.2	9.2	-129
Сэлбэг хэрэгсэл	4.5	2	-2.5
Түлш, шатах тослох материал	3.8	0.3	-3.5
Хүнсний материал	5.6	-	-5.6
Бусад хангамжийн материал	16.7	5.4	-11.3
Мал амьтад	15.1	24.1	-9

<b>Дүн</b>	<b>232.5</b>	<b>72.2</b>	<b>-160.3</b>
------------	--------------	-------------	---------------

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 72.2 сая төгрөгийн үлдэгдлийн 43.9 хувийг эм боох материал эзэлж байгаа бөгөөд тусгай зориулалтын, мал амьтад, эм боох материалын үлдэгдэл гол нөлөөлж байна. Мөн бараа материалын үлдэгдлийн 59.2 хувийг Засаг даргын Тамгын газар, 4.9 хувийг иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 35.9 хувийг эмийн эргэлтийн сан зэрэг байгууллагууд эзэлж байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,139.1 сая төгрөг болж, өмнөх оноос 6,238.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Барилга, байгууламж, орон сууц</b>	5,867.6	479.2	5,388.4
<b>Авто-тээврийн хэрэгсэл</b>	440.4	456.4	16.0
<b>Машин тоног төхөөрөмж(компьютер)</b>	666.3	167.8	-498.5
<b>Тавилга, аж ахуйн эд хогшил</b>	203.1	18.6	-184.5
<b>Бусад үндсэн хөрөнгө</b>	1,057.9	954.1	-103.8
<b>Ном</b>	47.2	0.00	-47.2
<b>Программ хангамж</b>	1.5	4.1	2.6
<b>Бусад биет бус хөрөнгө</b>	93.9	58.9	-35.0
<b>Дүн</b>	<b>8,377.9</b>	<b>2,139.1</b>	<b>-6,238.0</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 82.7 сая, үнэ төлбөргүй 18.7 сая, нийт 301.4 сая төгрөгөөр нэмэгдэж, Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөв буюу дээд шатын төсөв захирагчид шилжүүлсэн 6,504.4 сая, акталж данснаас хассан 35.7 сая, нийт 6,540.1 сая төгрөгөөр буурсан байна.

### Аудитын илрүүлэлт

- ОНХС-ийн хөрөнгөөр 6 төсөл арга хэмжээний ажлыг зураг төсөлгүй гүйцэтгэсэн. Одоо хэрэгжиж байгаа болон цаашид хэрэгжих зам, барилгын ажил гүйцэтгэсэн, төсөл, арга хэмжээнүүд магадлалаар баталгаажсан зураг төсөлгүй, техник технологийн хяналтын болон захиалагч, зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй, гэрээ байгуулсан боловч хяналтыг хэрэгжүүлээгүй тохиолдолд зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд барилгын ажлын санхүүжилтийн гүйцэтгэлийг баталгаажуулахгүй, санхүүжилт олгохгүй байх/ОНХС/

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 10.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Ажилчидтай холбогдсон өглөг</b>	4.0	0.00	-4.0
<b>Байгууллагад төлөх өглөг</b>	4.1	0.00	-4.1
<b>Хувь хүмүүст төлөх өглөг</b>	2.6	0.00	-2.6
<b>Дүн</b>	<b>10.7</b>	<b>0.0</b>	<b>-10.7</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,739.3 сая төгрөг болж, өмнөх оноос 5,816.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,107.6	355.5	-1,752.1
Хуримтлагдсан үр дүн	<b>4,826.7</b>	<b>1,282.2</b>	<b>-3,544.5</b>
Өмнөх үеийн үр дүн	3,011.1	7,065.3	-4,054.5
Тайлант үеийн үр дүн	1,815.6	-5,873.1	-4,057.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	621.5	101.6	-519.9
<b>Дүн</b>	<b>7,555.8</b>	<b>1,739.3</b>	<b>5,816.5</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цэвэр хөрөнгийн дүн 355.5 сая төгрөг болж 1,752.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр улсын төсвийн буюу дээд шатын төсөв захирагч нарт санхүүгийн тайланг нэгтгэж байгаагаас засгийн газрын оруулсан капитал 1,752.1 сая, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 519.9 сая, хуримтлагдсан үр дүн 3,705.8 сая нийт 5,977.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын залруулга хийж, тайлант үед 5,816.5 сая төгрөгийн үр дүнгүй ажилласан нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 04 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 294.4 сая төгрөг, татварын бус орлого 68.6 сая нийт 363.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр татварын орлого 373.1 сая, татварын бус орлого 29.1 сая нийт 402.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын гүйцэтгэл 110.8 хувиар давсан байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өссөн /Буурсан/
<b>НИЙТ ОРЛОГО</b>	362.9	402.2	39.3
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>294.3</b>	<b>373.1</b>	78.8
Хувь хүний орлогын албан татвар	<b>175.0</b>	<b>175.0</b>	0
Үйл ажиллагааны орлого	30.0	30.08	0.08
Хөрөнгийн орлого	20.0	22.2	2.2
Шууд бус орлого	2.1	6.9	4.8
Хөрөнгийн албан татвар	<b>104.8</b>	<b>80.1</b>	-24.7
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3.5	4.53	1.03
Бууны албан татвар	1.3	1.5	0.2
Малд ногдуулах албан татвар	100.0	74.0	-26
Бусад татвар (төлбөр, хураамж)	<b>14.5</b>	<b>67.9</b>	53.4
Бусал нийтлэг төлбөр, хураамж	<b>5.5</b>	<b>3.8</b>	-1.7
Улсын тэмдэгтийн хураамж	1.0	1.2	0.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.0	2.6	-1.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.5	0.0	-0.5
Газрын төлбөр	3.5	0.6	-2.9
Газрын төлбөр	3.5	0.6	-2.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр	5.5	63.4	57.9

Ан амьтны нөөц ашигласны төлбөр	5.0	63.4	58.4
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.5	0.03	-0.47
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>68.6</b>	<b>29.09</b>	<b>39.51</b>
Хүү, торгуулийн орлого	6.0	9.09	3.09
Бусад орлого	62.6	20.0	-42.6

Орон нутгийн татварын болон татварын бус орлого төлөвлөснөөс 39.3 сая төгрөгөөр давсан нь төлөвлөгдөөгүй ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого орсон нь нөлөөлсөн байна.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,176.7 сая төгрөг, нийт зардлыг 1,176.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тус сумын 2022 оны нэгтгэсэн төсвийг тайлант оны давсан орлого болон Төрийн үйлчилгээний албан хаагчдын ТҮ1-4 хоорондох цалинг улсын төсөвт шилжүүлсэнтэй холбоотойгоор иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 30 өдрийн №04 тогтоолоор нийт зардлыг 1,467.2 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 1,750.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,050.9 сая төгрөгийг урсгал зардалд, 599.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 100.0 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,100.0 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 338.5 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 52.0 сая, урьд оны үлдэгдлээс 81.9 сая нийт 1,408.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,408.6 сая төгрөг буюу 80.4 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдлийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/сая төгрөгөөр/			
№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага</b>					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	85.1	71.3	13.8	84%
2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	27.6	27.6	0.0	100%
3	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	5.0	5.0	0.0	99%
4	82201-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	4.5	4.5	0.0	100%
5	82706-Гоц халдварт өвчний голомтыг арилгах	0.9	0.8	0.1	91%
<b>Дүн</b>		<b>123.1</b>	<b>109.2</b>	<b>13.9</b>	
<b>70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	323.5	317.2	6.2	98%
2	80106- Баг хорооны үндсэн үйл ажиллагаа	66.9	66.6	0.2	100%
3	80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	31.0	30.2	0.8	97%
4	80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	6.1	6.1	0.0	100%
5	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	31.3	31.3	0.0	100%
6	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	28.0	25.8	2.2	92%
7	81701-Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	5.0	0.7	4.3	14%
8	82706-Гоц халдварт өвчний голомтыг арилгах	3.4	3.3	0.0	100%
9	83201- Ангилагдаагүй бусад зориулалт	62.8	57.5	5.3	92%
<b>Дүн</b>		<b>557.9</b>	<b>538.8</b>	<b>19.1</b>	
<b>71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>					

1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	23.3	18.8	4.5	81%
2	83201-ангилагдаагүй бусад зориулалт арга хэмжээ	5.3	4.5	0.8	85%
<b>Дүн</b>		<b>28.6</b>	<b>23.3</b>	<b>5.3</b>	
<b>71802 ерөнхий боловсрол</b>					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	99.1	79.1	19.9	80%
2	80112-нийтлэг үйлчилгээ	52.0	52.0	0.0	100%
<b>Дүн</b>		<b>151.04</b>	<b>131.10</b>	<b>19.93</b>	
<b>71702 соёл урлаг</b>					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	30.0	23.1	6.9	76.9%
2	80112-нийтлэг үйлчилгээ	11.8	10.2	1.6	86.3%
3	83201-ангилагдаагүй бусад зориулалт арга хэмжээ	4.5	4.5	0.0	100.0%
<b>Дүн</b>		<b>46.3</b>	<b>37.7</b>	<b>8.5</b>	<b>81.5%</b>
<b>70106-Орон нутгийн хөгжлийн сан</b>					
1	83401-итгэлцүүрээр	327.7	347.0	-19.4	105.91%
2	83402-хайгуулын тусгай зөвшөөрөл	1.5	0.0	1.5	0.00%
3	83403- Ашиглалтын тусгай зөвшөөлийн төлбөр	64.3	0.0	64.3	0.00%
4	83405-малын тоо толгойн албан татвар	100.0	93.0	7.0	93.00%
5	83406-ОНХС-бусад	10.1	10.1	0.0	100.00%
<b>Дүн</b>		<b>503.7</b>	<b>450.2</b>	<b>53.5</b>	<b>89.38%</b>
<b>72101 Жижиг дүнд үйлдвэрлэлийг дэмжих</b>					
2	83111-сум хөгжүүлэх	56.9	41.2	15.7	72.4%
<b>Дүн</b>		<b>56.9</b>	<b>41.2</b>	<b>15.7</b>	<b>72.4%</b>
<b>71801 сургуулийн өмнөх боловсрол</b>					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	109.6	79.2	30.40	72.3%
2	80112-нийтлэг үйлчилгээ	22.5	22.5	0.00	100.0%
3	83201-ангилагдаагүй бусад зориулалт арга хэмжээ	11.9	11.9	0.00	100.0%
<b>Дүн</b>		<b>144.0</b>	<b>113.6</b>	<b>30.4</b>	<b>78.9%</b>

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 100.4 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15.3 сая нийт 115.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байр ашиглалттай холбоотой зардал 4.6 сая, хангамж, бараа материалын зардалд 6.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 0.6 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 103.5 сая нийт 115.7 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 3.1 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түвшинширээ сумын санхүүгийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах орлоготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2023 оны 3 дугаар сарын 15 -аас 2023 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 1,291.8 сая төгрөгийн зардлын 2 хувь буюу 25.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

#### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 24.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тээвэр шатахууны зардал 4.0 сая, албан томилолтын зардал 0.3 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Дээрх зардал өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Тээвэр шатахуун, бичиг хэргийн зардал: Шатах тослох материал, бичиг хэргийн материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.*

#### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

<sup>1</sup> Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

#### Аудитын илрүүлэлт

- Шилэн дансны зарим мэдээллийг мэдээлэлгүй болон хоцроож мэдээлжээ / ОНХС, ЗДТГ/

#### **4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.7.1 Завсрын аудитын талаар**

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

##### **4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

*Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.*

*Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Зөвлөмж</b>	3	0	1	0	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100</b>

Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжүүлжээ.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 122.5 сая төгрөгийн зөрчил<sup>3</sup> илэрч зөвлөмж өгөв

### **5.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### ***Орлоготой холбоотой асуудал***

##### ***5.1.1 Илрүүлэлт:***

Малын тоо толгойн албан татвар 122.5 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 /Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна/, 5.2 /Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үндэслэн тодорхойлно./, **6 дугаар зүйлийн 6.2** /Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно/, **7 дугаар зүйлийн 7.1** /Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө/, **Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1** /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/ тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр Багийн засаг дарга, татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, биелэлтийг хангуулах, мөн уг албан татвараар төвлөрсөн хөрөнгийг буцаан малчдад үйлчилгээ үзүүлэх тохиолдолд татвар төлсөн байдлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэхийг зөвлөж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын Тамгын газар	1	21.5			1	21.5						
ОНХС	1	133.7			1	133.7						
Дүн	2	155.2				155.2						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг даргын Тамгын газар	1	0					1	0
ОНХС	1	0			1	0		
Дүн	2	0			1	0	1	0